



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/04/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a> Ахлах аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: <a href="mailto:Enkhchimeg@audit.gov.mn">Enkhchimeg@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
Агуулга.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4.2. Албан шаардлага .....	12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СХАА	Санхүү хяналт Аудитын алба
НББТХууль	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГА Д.ГАНДОЛГОР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүү хяналт, Аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүү хяналт, Аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,273,273.26</b>	<b>6,272,380.00</b>
33	АВЛАГА	14,863.26	0.00
33500	Бусад авлага	14,863.26	0.00
33510	Байгууллагаас авах авлага	14,863.26	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,258,410.00	6,272,380.00
35400	Хангамжийн материал	6,258,410.00	6,272,380.00
35410	Бичиг хэргийн материал	2,102,950.00	2,054,620.00
35420	Аж ахуйн материал	3,189,460.00	3,182,260.00
35440	Түлш, шатах тослох материал	966,000.00	1,035,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,058,473.99</b>	<b>12,388,056.71</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,058,473.99	12,388,056.71
39200	Биет хөрөнгө	17,058,473.99	12,388,056.71
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	21,221,002.00	21,221,002.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,980,617.50	-12,963,624.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,335,817.40	8,335,817.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,517,727.91	-4,205,137.83
39301	Програм хангамж	660,000.00	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-660,000.00	0.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>23,331,747.25</b>	<b>18,660,436.71</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,863.26</b>	<b>0.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,863.26	0.00
41300	Өглөг	14,863.26	0.00
41360	Бусад өглөг	14,863.26	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	14,863.26	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,316,883.99	18,660,436.71
51	Засгийн газрын хувь оролцоо	23,316,883.99	18,660,436.71
51200	Хуримтлагдсан үр дүн	23,316,883.99	18,660,436.71
51210	Өмнөх үеийн үр дүн	22,390,010.53	23,316,883.99
51220	Тайлант үеийн үр дүн	926,873.46	-4,656,447.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>23,331,747.25</b>	<b>18,660,436.71</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>161,128,100.00</b>	<b>149,780,300.00</b>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,128,100.00	149,780,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	161,128,100.00	149,780,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	161,128,100.00	149,780,300.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>160,201,226.54</b>	<b>154,436,747.28</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,201,226.54	154,436,747.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,212,452.30	152,762,159.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,341,107.00	120,797,296.00
210101	Үндсэн цалин	112,296,107.00	112,892,296.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,045,000.00	7,905,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,703,220.14	15,291,816.66
210201	Тэтгэврийн даатгал	10,202,205.27	10,799,369.19
210202	Тэтгэмжийн даатгал	1,200,259.44	1,198,559.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	960,207.55	1,148,461.96
210204	Ажилгүйдлийн даатгал	212,777.08	195,038.77
210205	Эрүүл мэндийн даатгал	2,127,770.80	1,950,387.48
2104	Хангамж, бараа материалын зардал	4,101,986.00	3,919,730.00
210401	Бичиг хэрэг	1,657,470.00	1,694,130.00
210402	Тээвэр, шатахуун	2,134,000.00	1,880,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,516.00	272,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,400,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,400,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	7,292,000.00	7,482,900.00
210702	Дотоод албан томилолт	7,292,000.00	7,482,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	725,000.00	100,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	625,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,649,139.16	5,170,417.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,700.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,944,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,595,439.16	4,670,417.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,988,774.24	1,674,587.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	580,000.00	493,110.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	580,000.00	493,110.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,408,774.24	1,181,477.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,408,774.24	1,181,477.34
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>926,873.46</b>	<b>-4,656,447.28</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>926,873.46</b>	<b>-4,656,447.28</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	21,281,103.70	21,281,103.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,108,906.83	1,108,906.83
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	22,390,010.53	22,390,010.53
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	926,873.46	926,873.46
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	23,316,883.99	23,316,883.99
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	23,316,883.99	23,316,883.99
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	23,316,883.99	23,316,883.99
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-4,656,447.28	-4,656,447.28
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	18,660,436.71	18,660,436.71

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>161,128,100.00</b>	<b>149,780,300.00</b>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,128,100.00	149,780,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	161,128,100.00	149,780,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	161,128,100.00	149,780,300.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>157,682,950.00</b>	<b>149,780,300.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,682,950.00	149,780,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,694,175.76	148,105,712.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,234,419.76	120,797,430.00
210101	Үндсэн цалин	109,994,419.76	112,958,731.40
210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,240,000.00	7,838,698.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,701,000.00	15,291,682.66
210201	Тэтгэврийн даатгал	10,195,800.00	10,799,369.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,199,500.00	1,198,559.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	959,600.00	951,713.92
210204	Ажилгүйдлийн даатгал	210,557.00	212,912.77
210205	Эрүүл мэндийн даатгал	2,135,543.00	2,129,127.40
2104	Хангамж, бараа материалын зардал	7,092,906.00	3,883,700.00
210401	Бичиг хэрэг	2,349,990.00	1,550,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,100,000.00	1,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,516.00	383,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,332,400.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,524,850.00	0.00
210602	Тавилга	124,850.00	0.00
210604	Урсгал засвар	1,400,000.00	0.00
2107	Томиллолт, зочны зардал	7,292,000.00	7,482,900.00
210702	Дотоод албан томиллолт	7,292,000.00	7,482,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	725,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	625,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,124,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,124,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,988,774.24	1,674,587.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	580,000.00	493,110.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	580,000.00	493,110.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,408,774.24	1,181,477.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,408,774.24	1,181,477.34
213404	Хөрөнгийн	0.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,445,150.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,445,150.00</b>	<b>0.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,445,150.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,445,150.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,445,150.00	0.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-3,445,150.00</b>	<b>0.00</b>
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>149,780,300.00</b>	<b>148,598,822.66</b>		
				1,181,477.34	99%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,780,300.00	148,598,822.66	1,181,477.34	99%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	149,280,300.00	148,105,712.66	1,174,587.34	99%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,803,200.00	120,797,430.00	5,770.00	100
210101	Үндсэн цалин	113,103,200.00	112,958,731.40	144,468.60	99%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,700,000.00	7,838,698.60	-138,698.60	101%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,443,400.00	15,291,682.66	1,151,717.34	93%
210201	Тэтгэврийн даатгал	11,571,300.00	10,799,369.31	771,930.69	93%
210202	Тэтгэмжийн даатгал	1,218,000.00	1,198,559.26	19,440.74	98%
210203	ҮОМШӨ-ний даатгал	974,400.00	951,713.92	22,686.08	97%
210204	Ажилгүйдлийн даатгал	243,600.00	212,912.77	30,687.23	87%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,436,100.00	2,129,127.40	306,972.60	87%
2104	Хангамж, бараа материалын зардал	3,883,700.00	3,883,700.00	0.00	100%
210401	Бичиг хэрэг	1,550,000.00	1,550,000.00	0.00	100%
210402	Тээвэр, шатахуун	1,950,000.00	1,950,000.00	0.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	383,700.00	383,700.00	0.00	100%
2107	Томиллолт, зочны зардал	7,500,000.00	7,482,900.00	17,100.00	99%
210702	Дотоод албан томиллолт	7,500,000.00	7,482,900.00	17,100.00	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,000.00	150,000.00	0.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00	0.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00	0.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	493,110.00	6,890.00	98%
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	493,110.00	6,890.00	98%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	493,110.00	6,890.00	98%
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>149,780,300.00</b>	<b>148,598,822.66</b>		
				1,181,477.34	99%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	149,780,300.00	148,598,822.66	1,181,477.34	99%
320001	Орон нутгийн төсвөөс	149,780,300.00	148,598,822.66	1,181,477.34	99%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	15	15	0	100%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100%
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7	0	100%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	0	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7	7	0	100%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	6	1	100%

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, Аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 6 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Санхүү хяналт, Аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр шалгагдсан тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг аймгийн Засаг харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрддөг хууль, журамд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2021.04.08

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 149.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 23.3 сая төгрөгөөр буюу 19.7 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая.төг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	0.04		-0.04	-100.0
Бараа материал	6.2	6.3	0.1	1.6
Үндсэн хөрөнгө	17.1	12.4	-4.7	-27.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>23.3</b>	<b>18.7</b>	<b>-4.6</b>	<b>-19.7</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	23.3	18.7	-4.6	-19.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	23.3	18.7	-4.6	-19.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын данс нь 0.01 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлагыг бүрэн барагдуулсан байна.
- Бараа материалын үлдэгдэл 1.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 6.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 0.1 сая төгрөг нийт 6.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 27.5 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 17.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 4.7 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 12.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант үеийн үр дүн 4.6 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүн буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Орон нутгийн төсвөөс	161.1	149.8	(11.3)
Бусад орлого	1.1		(1.1)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>162.2</b>	<b>149.8</b>	<b>(12.4)</b>
Цалин, шимтгэлийн зардал	135.0	136.1	1.1
Бусад бараа үйлчилгээний зардал	12.9	11.2	(1.7)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.7	0.1	(0.6)
Бараа үйлчилгээний бусад зардал	8.6	5.2	(3.4)
Урсгал шилжүүлэг	3.0	1.8	(1.2)
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>160.20</b>	<b>154.4</b>	<b>(5.8)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>2.00</b>	<b>-4.60</b>	<b>-6.60</b>

Санхүү хяналт, Аудитын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 11.3 сая төгрөг буурсан байна. Энэ нь бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 230.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 81.1 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 149.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 149.8 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бүрэн авч 148.6 сая төгрөгийг зарцуулж 1.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн автомашингүй тул албан ажлын хэрэгцээнд бусад байгууллага болон албан хаагчдын хувийн автомашиныг хэрэглэж шаардагдах шатахууныг олгож ажилладаг байна.

Санхүү хяналт, Аудитын алба нь тээвэр шатахууны зардалд оны эхний үлдэгдэл 1.0 сая төгрөг, тайлант онд 2.0 сая төгрөг зарцуулахаар төлвөлсөн бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд бусад байгууллага болон албан хаагчдын хувийн автомашиныг хэрэглэж тээвэр шатахууны зардал нийт 1.9 сая төгрөгийг зарцуулж, 1.1 сая төгрөгийн шатахууны /толан/ хэмнэлт бий болгосон байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 98.1 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 149.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.2 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд:
  - Бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
  - Тайлангийн жилд тус байгууллагын 7 ажилтанг УБ хотод эрүүл мэндийн үзлэгт хамруулахад томилолтын зардалд 1.9 сая төгрөгийг зарцуулсан байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн автомашингүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд бусад байгууллага болон албан хаагчдын хувийн автомашиныг хэрэглэж тээвэр шатахууны зардал нийт 1.9 сая төгрөгийг олгосон байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Энэ санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгасан үр дүнг доор харууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад 2021 онд 149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад зөрчилтэй асуудал илрээгүй байна. Төсвийн

хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар авч үзэхэд 1.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан ба аудитаас зөвлөмж өгөөгүй байна.

Тус байгууллагын 2021 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд зөрчил илрээгүй.

### **3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно. Иймд Зөрчилгүй дүгнэлт өглөө.

-----oOo-----

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Санхүүгийн хяналт, Аудитын алба		0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Дүн</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Санхүүгийн хяналт, Аудитын алба		1	0	0	0	1	0	0	0	1	0
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>
Нийт дүн		1	0	0			0	0	0	1	0